



МУХАУТ-ЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

ЭРХЭМ ЗОРИЛГО

МҮХАҮТ нь бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд нөлөөлөгч, өмгөөлөгч, бизнесийн хөгжилд чиглүүлэгч, холбогч, дэмжигч байна.

АЛСЫН ХАРАА


МҮХАҮТ нь бизнесийн амжилтын ТАЛБАР байж, дэлхийн зах зээлийн өрсөлдөөнд манлайлахад ХӨТӨЧ нь болно.

ҮНЭТ ЗҮЙЛС

- Чадварлаг, эвсэг хамт олон
- Нягт, үр дүнтэй хамтын ажиллагаа
- Үнэ цэнэтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ
- Ёс зүйт үйл ажиллагаа
- Манлайлал

МҮХАУТ-ЫН СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

2020-2023



1. БИЗНЕСИЙН ОРЧНЫ БОЛОН БОДЛОГЫН ШИЙДЛИЙГ ТОДОРХОЙЛОХ ЧАДАМЖТАЙ БАЙХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

1.1 Бодлогын баримт бичиг боловсруулах, хүргүүлэх

- Бизнесийн 4 салбарын байр суурийн баримт бичиг гаргах. (Эдийн засгийн бодлого тодорхойлоход гол салбаруудын байр суурийн баримт бичгийг урьдчилан боловсруулах)
- Улсын төсвийн хүрээний мэдэгдэл ба төсвийн төсөлд санал, зөвлөмж өгөх
- ТОП-10 арга хэмжээ зохион байгуулах

1.2 Бизнесийн хууль эрх зүйн орчинг сайжруулах

Бодлогын баримт бичиг, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгүүдэд орж ажиллан, уулзалт хэлэлцүүлгүүд зохион байгуулж, бизнес эрхлэгчдээс гарсан саналыг нэгтгэн төр засагт хүргэн ажиллах: Үүнд:

- Төр хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн ажлын хэсэгт ажиллах
- Зөвшөөрлийн тухай хуулийн ажлын хэсэгт ажиллах
- Төрийн худалдан авалтын тухай хуулийн төслийн ажлын хэсэгт ажиллах
- Хөрөнгө оруулалтын тухай хуулийн ажлын хэсэгт ажиллах
- Зар сурталчилгааны тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллах
- Хууль эрх зүйн баримт бичгийн төсөлд санал боловсруулах
- Бизнесийн хууль эрх зүйн орчны асуудлаар уулзалт хэлэлцүүлгүүд зохион байгуулах
- Хууль эрх зүйн асуудлаар төрийн байгууллагууд ба бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах

1.3 Худалдааны гэрээ, хэлэлцээр байгуулах, хэрэгжүүлэхэд идэвхтэй хамтран ажиллах

- Монгол улсаас БНСУ-тай байгуулах Чөлөөт Худалдааны судалгааны ажлын хэсэгт хамтарч ажиллах
- Япон улстай байгуулсан ЭЗТХ-ийн хэрэгжилтийг хангах ажлын хэсэгт ажиллах
- Евро Азийн Эдийн Засгийн Комисстой Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах ажлын хэсэгт ажиллах

1.4 Танхимын хууль эрх зүйн шинэчлэлийг хийх

- Танхимын хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал бэлтгэх, уулзалт хэлэлцүүлгүүд зохион байгуулах.

1.5 Танхимын дэргэдэх зөвлөлүүдийн үйл ажиллагааг тогтвортой явуулах, идэвхжүүлэх

МҮХАҮТ-ын дэргэд эдийн засгийн бодлого, хууль зүйн бодлого зэрэг ерөнхий чиглэлийн, салбарын бодлогын, бизнесийн үйл ажиллагааг дэмжих, хамтын ажиллагааны чиглэлээр бизнесийн зөвлөлүүд үйл ажиллагаа явуулж байна. Зөвлөлийн үндсэн үйл ажиллагаа нь:

- Салбарын бизнес, эдийн засаг, хууль эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр бизнес эрхлэгчдийн саналыг нэгтгэн, төр засагт хүргүүлэх
- Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Гишүүд хоорондын уялдаа холбоог сайжруулж, мэдээ мэдээллээр хангах

2. БОДЛОГОД НӨЛӨӨЛДӨГ БАЙХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

2.1 Бизнесийн орчны судалгаа явуулах, дүн шинжилгээ хийх

- Бизнесийн итгэлийн индекс-2021 судалгаа
- Хүнд суртлын индекс-2021 судалгаа
- 2021 оны ТОП-100 ААН эрэмбэлэх
- Аялал жуулчлалын салбарын судалгаа
- Экспортын гол нэрийн бүтээгдэхүүний судалгаа
- Гол нэрийн түүхий эд, бүтээгдэхүүний зах зээлийн үнийн тойм бэлтгэн гаргах
- Сар бүрийн эдийн засаг, бизнесийн тойм гаргах

2.2 Эдийн засаг, аж үйлдвэрийн салбарын мэдээллийн санг бүрдүүлэх

- Олон улс, бүс нутаг болон Монгол улсын эдийн засгийн мэдээллүүдээр мэдээллийн сан үүсгэх, тогтмол шинэчлэх
- Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд ба гол салбаруудын талаар мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, танилцуулга бэлтгэх
- Экспорт импортын гол барааны товхимол гаргах

3. ОЛОН НИЙТЭД НӨЛӨӨ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА БАЙЖ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН НЭР ХҮНДИЙГ ӨРГӨХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

3.1 Гишүүдийн тоог нэмэгдүүлэх

- Гишүүдийн тоог өсгөж, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх
- Гишүүн байгууллагуудын “Trademongolia.mn” сайтын ашиглалтыг нэмэгдүүлэх, олон нийтэд түгээх, сурталчлах

- Гишүүд болон бизнес эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, хэрэгжүүлэх
 - Бизнес, эдийн засаг, худалдааны мэдээллийн сан үүсгэн, мэдээллийн санд тулгуурлан дата мэдээлэл бэлтгэж өгөх, судалгаа хийх үйлчилгээ үзүүлэх
 - Экспортын экспертизийн үйлчилгээг нэвтрүүлэх

3.2 Гишүүд, бизнес эрхлэгчдийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

- Монгол улсад хийх төрийн ба бизнесийн айлчлалын хүрээнд бизнес уулзалтууд зохион байгуулах
- Хоёр талт болон олон талт уулзалтуудыг цахимаар болон танхимаар хийх
- Олон улсын худалдааны танхим, Худалдааг дэмжих байгууллагууд, Дэлхийн танхимуудын холбоо, Азийн худалдааг дэмжих форум, Ази номхон далайн орнуудын худалдаа аж үйлдвэрийн танхимуудын холбоо, Торгоны зам олон улсын худалдааны танхим зэрэг худалдааг дэмжих байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх
- Монгол Улсаас гадаадад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, Өргөмжит консулууд болон Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудтай хамтын ажиллагааг идэвхжүүлэх

3.3 ЖДҮ эрхлэгчдийг дэмжих, хөгжүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах. Үүнд:

- ЕХ-ны санхүүжилттэй Bridge төсөл (2022/01-2022/10)
- "Эмэгтэйчүүдийг эдийн засгаар чадавхижуулах" АХБ, ХЗДХЯ -ны төслийн хүрээнд МҮХАҮТ, Эдукэйтэд ХХК консерциумын зөвлөх үйлчилгээ (2020-2022 он)
- Хүүхдийг ивээх сангийн Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох төсөл 2020/05-2024/05
- ЖАЙКА MonMap төсөл (2020/03/15-2024/03/15)
- Азийн сан "Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх" төсөл (2021/08/16-2022/08/16)
- НҮБ-ын системийн байгууллагуудтай хамтран ажиллах (2022/01-2022/10)
- "Бизнесийн ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэх төсөл" (2021/03-2022/03)
- Switch Asia "Монголын Сарлагийн ширний кластерыг чадавхижуулах" төсөл (2021/12-2025/12)
- ЕвроЧэймбэр МҮХАҮТ-ын хамтарсан Экспортын бэлэн байдлын үнэлгээ хийх төсөл (2021-2022)

➤ Органик Монгол хөтөлбөр хэрэгжүүлэх;

- Сэлэнгэ, Дархан аймгуудад
- 2022 оноос + Хэнтий аймагт

➤ ЖДҮ дэмжих, чадавхижуулах чиглэлээр төслийн санал боловсруулж, олон улсын байгууллагуудад өргөдөл гаргах, санхүүжилт олж, хэрэгжүүлэх

- **Танхимын дэргэд ажиллаж буй кластеруудын үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх, экспортын боломж потенциал бүхий бүтээгдэхүүний кластер шинээр байгуулж, хөгжүүлэх**

3.4 Гишүүд, бизнес эрхлэгчдийг дэмжин урамшуулах төрөл бүрийн арга хэмжээг үр дүнтэй, шинэлэг хэлбэрээр зохион байгуулах

- “ТОП-100” ёслолын ажиллагаа
- "Үндэсний чанарын чуулган"
- Оны онцлох ААН шалгаруулах "Entrepreneur" ёслолын арга хэмжээ
- Оны шилдэг ААН-ийн туг өргөх ёслол, аян зохион байгуулах

3.5 Гишүүд, бизнес эрхлэгчдэд хэрэгцээтэй гадаад, дотоод уулзалт, хэлэлцүүлгийг үр дүнтэй зохион байгуулах

- Төр хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах уулзалт, арга хэмжээ
 - Бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, ханган нийлүүлэлт болон туршлага солилцох уулзалтууд
 - Олон улсын экспортын форум
 - Экспортын тээвэр логистикийг сайжруулах уулзалт
 - Монгол Японы бизнесийн харилцааг идэвхжүүлэх нь" сэдэвт семинар
- Гадаад худалдааг хөгжүүлэх чиглэлээр төрөл бүрийн сургалт семинар
 - Бичил , жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрт хамруулах, сургалт зохион байгуулах

3.6 Үзэсгэлэн зохион байгуулах;

- Гадаад үзэсгэлэн
 - “IFFA 2022” Мах махан бүтээгдэхүүний үзэсгэлэн, ХБНГУ-ын Франкфурт, 5 дугаар сарын 14-19 ны өдрүүдэд
 - “Франчайзын үзэсгэлэн”, АНУ-ын Нью Йорк хотноо 6 дугаар сарын 2-4-ны өдрүүдэд
 - “Иннопром-2022” олон улсын аж үйлдвэрийн 12 дахь удаагийн үзэсгэлэн, ОХУ- Свердловск мужийн Екатеринбург хот, 7 дугаар сарын 4-7-ны өдрүүдэд
 - “Төв Азийн олон улсын худалдааны цахим үзэсгэлэн”, БНХАУ,
 - “Drug store Japan 2022” Япон улсын хамгийн том эм, эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн, Токио хотноо, 8 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд
 - “Монгол- Оросын-Хятадын 3-н талт чуулга уулзалт, үзэсгэлэн”, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хот, 9 дүгээр сард
 - "Canton fair 2022" үзэсгэлэн, БНХАУ-ын Гуанжөү хот, 10 сарын 15-19

- “EVTEKS-2022” нэхмэл эдлэл, гэр ахуйн бүтээгдэхүүний үзэсгэлэн, БНТУ-ын Истанбул хот, 11 дүгээр сарын 1-5-ны өдрүүдэд
- “Bazaar Berlin- 2022” бэлэг дурсгал, гэр ахуйн бүтээгдэхүүний үзэсгэлэн, ХБНГУ-ын Берлин хот, 11 дүгээр сарын 02-06 ны өдрүүдэд
- Хятадын 5 дахь удаагийн “Олон улсын импортын экспо”, БНХАУ-ын Шанхай хот
- "Фүүд Кореа-2022", 11-р сард
- “Цагаан сарын үзэсгэлэн”, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хот, ССРIT
- "Шинэ жилийн үзэсгэлэн", БНХАУ-ын Хайнан хот

➤ Дотоод үзэсгэлэн

- "Жижиг дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлчилгээ технологи" Олон улсын үзэсгэлэн худалдаа, 2022 оны 5 дугаар сарын 19-22 өдрүүдэд
- Монгол туургатны өв соёлын нааам арга хэмжээ
- "Улаанбаатар түншлэл" Олон улсын үзэсгэлэн худалдаа, 2022 оны 9 дүгээр сарын 22-25 өдрүүдэд

3.7 Салбар Танхимуудын үйл ажиллагааг дэмжих, удирдлага зохицуулалтаар хангах

- Салбар танхимуудыг мэдээ, мэдээллээр хангах
- Салбар Танхимын сумдад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх замаар гишүүдийн тоог 10% нэмэгдүүлэх
- Салбар танхимын барилгын нэгдсэн зураг

3.8 Танхимын үндсэн үйлчилгээнүүдийг үзүүлэх;

- Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг 80% хүргэх
- Үйлчилгээний бүртгэл мэдээллийг бүрэн цахимжуулах
- Экспортын барааны гарал үүслийн гэрчилгээ
- АРТА /Ази, номхон далайн худалдааны хэлэлцээрийн хүрээнд гарал үүслийн гэрчилгээ олгох/
- ЕХ-ны REX буюу “Бүртгэгдсэн экспортлогчдын систем”-д аж ахуйн нэгжийг бүртгэх
- Аж үйлдвэрийн өмчийн эрхийн хамгаалалтыг хийх
- АТА карней формыг олгох
- Давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ олгох
- Органик бүтээгдэхүүн ба Ногоон буудал, Эко шошго олгох
- Экспертизийн үйлчилгээ

3.9 Гишүүн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн захирлууд, удирдах албан тушаалтнуудад манлайллын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, менежерийн сургалт зохион байгуулах

- Менежментийн шинэ хандлага, шилдэг арга хэрэгслийн цогц шийдлээр инновацид чиглэсэн Бизнесийг чадварлаг удирдаж, хүчирхэг компанийг бий

- болгох мэргэшсэн удирдлагыг бэлтгэх
- Бодит кейс дээр ажиллаж асуудлыг шийдвэрлэх оролцооны аргад суурилсан практик интерактив сургалтуудыг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулах.

Сургалтууд:

- СТРАТЕГИ
- МЕНЕЖМЕНТ & МАНЛАЙЛАЛ
- ЭНТРЕПРЕНЕР & ИННОВАЦИ
- САНХҮҮ & ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
- ХЭЛЦЭЛ ТОХИРОЛЦОЛ & ШИЙДВЭР ГАРГАЛТ
- КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ
- ТАЛЕНТ МЕНЕЖМЕНТ
- ГАДААД ХУДАЛДАА, САНХҮҮГИЙН МЕНЕЖЕР

3.10 Арбитр

- Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэвийн явуулах
- Арбитрын хуралдааныг цахим хэлбэрээр хийх
- “Цахим арбитр” төсөл хэрэгжүүлэх
- Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийг шинэчлэн батлуулах
- Арбитрын үйл ажиллагааг олон нийтэд таниулах, сурталчлах, сургалт судалгааны чиглэлээр үйл ажиллагааг хөгжүүлэх

3.11 Маркетинг, сурталчилгааг сайжруулах

- Гишүүдийг сурталчлах
- Сарын ньукслеттер хийх
- Трэд Монголиа.мн порталыг сурталчлах
- Сошиал акци, кампанит ажил зохион байгуулах
- Танхимын үйл ажиллагааг сурталчлах Chamber podcast бэлтгэн, олон нийтэд хүргэх

Танхимын хүний нөөцийг чадавхжуулах, хариуцлагыг сайжруулах хүрээнд:

1. Хүний нөөцийн стратеги, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах
2. Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотой холбогдох баримт бичиг боловсруулах, шинэчлэн батлуулж, мөрдүүлэх
3. Мэдээлэл үйлчилгээний нэгдсэн системийг шинэчлэх, хөгжүүлэх
4. Ажилтнуудыг ая тухтай ажиллах орчноор хангах